

ХОРИХ БАЙГУУЛЛАГАД МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИС НЭВТРЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ

О.Эрдэнэсайхан

ДХИС-ийн Удирдлагын академийн 8023 дамжааны суралцагч, магистрант,

Товч агуулга: Энэхүү илтгэлээр хорих байгууллагад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис нэвтрэхээс урьдчилан сэргийлэх ажлын “бодлого тодорхойлох түвшин” буюу “удирдлага, зохион байгуулалтын асуудлын хүрээнд” тулгамдаж буй асуудлыг илрүүлж, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхийг тус тус зорилоо.

Түлхүүр үгс: Аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтын асуудал, хорих байгууллагад хар тамхи болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис нэвтрэхээс урьдчилан сэргийлэх асуудал.

Abstract: The article is devoted to will soon begin to enforce the restraining punishment of restriction on freedom of travel, implementing and improving critical issues in implementing and improving the use of electronic bracelet used by foreign countries and highlighting some of the issues that need to be addressed.

Keywords: electronic bracelet, convict, punishment, electronic monitoring, punishment of restriction on freedom of travel.

Оршил

Манай улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг халж, зах зээлийн нийгэмд шилжсэнээр нийгэм, эдийн засагт олон өөрчлөлт, шинэчлэлийг авч ирсэн хэдий ч шилжилтийн үеийг дагаад “...мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгчийн тоог жил ирэх тутам нэмэгдүүлж, улмаар байнга хэрэглэгчдийн давхарга бий болж, хууль бус эргэлт, нийлүүлэлт тасралтгүй өссөөр байгаа...” нь энэ нийгмийн хамгийн тулгамдсан асуудлууд нэг болоод байна¹.

“...Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгч болон байнгын хэрэглэгчдийн

давхарга бий болсон...” явдал нь энэ төрлийн мансууруулах бодисын төрөл зүйлийг мөн нэмэгдүүлж, хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт насанд хүрээгүй хүн, залуучууд ихээр холбогдож, ял шийтгэгдэж буй хүний тоо ч сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдсээр байна.

2021 онд улсын хилээр хууль бусаар мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодис нэвтрүүлсэн 16, 2022 онд 18 хэрэг бүртгэгдэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үүсгэн шалгасан бол 2023 оны

¹ Хосбаяр.Г, Хорих байгууллагад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис нэвтрэхээс урьдчилан сэргийлэх ажиллагаа, анхаарах асуудал. “Хууль сахиулахын

удирдлага онол, арга зүйн сэтгүүл”. Дотоод Хэргийн Их Сургууль. 2021 он. № 2. 103 дахь тал.

эхний хагас жилийн байдлаар 6 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдаж байна¹.

Гэмт хэрэг үйлдсэн аргыг авч үзвэл: БНХАУ-аас 17 удаа мансууруулах эм сэтгэгцэд нөлөөт бодисыг улсын хилээр биедээ болон ачаа тээшиндээ хийж нэвтрүүлсэн үйлдэл гарсан бол 2020 онд 5, 2021 онд 12, 2022 онд 1 удаа олон улсын шуудан илгээмж ашиглан улсын хилээр мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисыг хууль бусаар нэвтрүүлсэн тохиолдол бүртгэгдэн шалгагдаж сүүлийн 2 жилийн тоон мэдээг харьцуулан харвал 2022 онд улсын хэмжээнд энэ төрлийн 199 хэрэгт 412 хүн холбогдон шалгагдсан бол 2023 онд 285 хэрэгт 427 хүн холбогдон шалгагдсан нь энэ төрлийн гэмт хэргийн гаралтын тоо, холбогдогчдын тоо жил ирэх тусам тогтмол нэмэгдэж байгааг харуулж байна.²³

Бидний мөнхийн хөршүүд болох Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Оросын Холбооны Улсууд нь эрүүгийн ялын бодлогодоо “...хар тамхи болон мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт харьцангуй чанга...” бодлогыг баримталж, энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хойд хөршид “бүх насаар нь хорих”⁴ урд хөршид “цаазаар авах”⁵ хүртэл ял, шийтгэлийг оногдуулж байна.

¹ Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн тайлангаас

²³Б.Алтангэрэл. Гэмт хэрэгтний нийтлэг хэв шинж, сэтгэхүйн онцлог/мансууруулах эм сэтгэгцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг үйлдсэн хоригдлын жишээн дээр/. УБ., 2022. 3 дахь тал.

Монгол

Улсын

“...мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт оногдуулах ялын бодлого хөрш орнуудаас харьцангуй зөөлөн...” болон “...энэ төрлийн бодисын түүхий эд болон мансууруулах үйлчилгээтэй ургамал байгальд зэрлэг байдлаар ургадаг, тархац их, түүнд тавих хяналт сул, энэ төрлийн бодисын үнэ дэлхийн дунджаас өндөр байгаа ...” зэрэг нь эрүүгийн нөлөө бүхий гэх тодотголтой этгээдүүд, гадаад улсын гэмт бүлэглэлүүдийн анхаарлыг татаж, тэдний үйл ажиллагаа манай улсруу чиглэх хандлага ажиглагдсаар байгааг энд дурдах нь зүйтэй билээ.

Нэг. Үндсэн хэсэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 2024 оны 03 дугаар сарын байдлаар гадаадын иргэн -32, хаалттай тусгай нэгжид – 33, хаалттай тусгайд эрэгтэй – 810, эмэгтэй – 6, хаалттай энгийн эрэгтэй 342, эмэгтэй – 9, нээлттэй дэглэмд эмэгтэй –266, өсвөр насны хүн 34, эрэгтэй –3237, нийт 4456 хүн хорих ял эдэлж байна.

Хорих ял шийтгүүлсэн хоригдлуудын тухайд 2017 шинэчлэн батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан үйлдсэн гэмт хэргийн хор аюулаас шалтгаалан нээлттэй, хаалттай тусгай дэглэмд хорих ял эдэлж байгаа бөгөөд Шүүхийн

³Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн тайлангаас

⁴Хандсан огноо. 2024.03.10: ["Уголовный кодекс Российской Федерации" \(УК РФ\) от 13.06.1996 N 63-ФЗ \(последняя редакция\) \ КонсультантПлюс \(consultant.ru\)](#)

⁵Хандсан огноо. 2024.03.10: [Уголовный кодекс Китайской Народной Республики \(china-embassy.gov.cn\)](#)

шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 407 дугаар, нээлттэй хаалттай хорих ангид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой зүйл ангиар шийтгүүлсэн-7, 409 дүгээр хаалттай хорих ангид-2, Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага, өсвөр насны хүн-2, 413 дугаар ангид-19, 415 дугаар ангид-9, 417 дугаар ангид-15, 419 дүгээр ангид-4, 421 дүгээр ангид-19, 423 дугаар ангид-22, 425 дугаар ангид-4, 427 дугаар ангид-14, 429 дүгээр ангид-4, 433 дугаар ангид-4, 433 дугаар ангид-2, 435 дугаар ангид-2, 437 дугаар ангид-7, 441 дүгээр ангид-2, 445 дугаар ангид-8, Цагдан хорих 461 дүгээр ангид-3, нийт 151 хоригдол хорих ял эдэлж байна¹.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хорих ял шийтгүүлсэн нийт хоригдлуудын дүнтэй харьцуулахад нийт 3.5 хувийг “...мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой...” зүйл ангиар шийтгүүлсэн хоригдлууд эзэлж байгаа болон тоон үзүүлэлт бага түвшинд харагдаж байгаа хэдий ч “...сүүлийн 3 жилийн байдлаар 0.5% – 3.5 хувь болтлоо өссөн болон мансууруулах бодис хэрэглэсэн, бусдад дамжуулсан үндэслэлээр насанд хүрээгүй 2 хүн ял шийтгүүлсэн байгаа нь...” ихээхэн анхаарал татаж байна.

2023 онд орон нутгийн хэмжээнд 119, нийслэлийн хэмжээнд 204 нийт 323 хэрэгт 722 хүн холбогдон шалгагдаж, сэтгэцийн эрүүл мэндийн төвд 62 иргэн сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдаж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт

бодистой холбоотой гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэгдсэн 151 хоригдол хорих байгууллагад ял эдэлж байна. Энэ тоон үзүүлэлтийг 2022 онтой харьцуулахад энэ төрлийн гэмт хэрэг 69 хувь, холбогдогч 9.6 хувиар өсч, эмнэлгийн үйлчилгээ авсан иргэдийн тоо 11.5 хувиар буурсан бол мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэсэн, хадгалсан, худалдан борлуулсан гэмт хэрэгт холбогдсон хоригдлын тоо 20 хувиар өссөн үзүүлэлттэй байна².

Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдсан иргэн болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлсэн хоригдлын тоо өссөнөөс гадна гол анхаарал татаж буй асуулал нь “...мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэсэн, хадгалсан, борлуулсан гэмт хэргээр шийтгүүлсэн...” хоригдлын сүүлийн 3 жилийн байдлаар 10-20 хувиар өссөн болон энэ төрлийн гэмт хэрэгт насан хүрээгүй хүн буюу эрх зүйн чадамж муу хүүхэд холбогдож, хорих ял шийтгүүлсэн байгаа нь судлаачийн анхаарлыг ихээхэн татсан болно.

Сүүлийн 3 жилийн байдлаар “...мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэсэн, хадгалсан, борлуулсан гэмт хэргээр шийтгүүлсэн...” хоригдлын тоо 20 хувиар өссөн, насанд хүрээгүй хүн энэ төрлийн зүйл ангиар шийтгүүлсэн...” байгаа нь “...хар тамхи буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг манай нийгэмд иууд хэрэглэж байгаа хүний тоо болон хадгалах, борлуулах асуудал

¹Б.Алтангэрэл. Албадан эмчлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт. УБ., 2023. 25 дахь тал.

²Цагдаагийн ерөнхий газрын харьяа хар тамхитай тэмцэх газрын 2023 оны тайлангаас

нэмэгдэж байгаатай...” шууд холбоотой гэж үзэж байна.

Хорих байгууллагад хорих ял эдэлж байгаа “...мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэсэн, хадгалсан, борлуулсан гэмт хэргээр шийтгүүлсэн...” хоригдлын тоо хурдацтай нэмэгдсээр байгаа нь “...хорих байгууллага, алба хаагчийн аюулгүй байдалд асар их хэмжээгээр сөргөөр нөлөөлж, хорих байгууллагын энэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодисыг нэвтрүүлэх, хэрэглэх, улмаар хорих байгууллагын хэмжээнд онцгой нөхцөл бий болохоос урьдчилан сэргийлэх ажлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох цаг үеийн шаардлагыг болгож байна...” гэж судлаачийн зүгээс үзэж байна.

“...Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил хорих байгууллагад үйлдэгдэх боломжит эрсдэл болон хорих байгууллагад хориотой эд зүйл нэвтрүүлэх, хэрэглэх болон хорих байгууллагад болзошгүй гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх, түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох...” асуудал нь хэрэгжүүлэх арга замын хувьд харилцан хамааралтай гэж судлаачийн зүгээс үзсэн бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “...хорих байгууллага болон алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлын удирдлага, зохион байгуулалтын асуудал...”-ыг хэрхэн зохицуулсан талаар энд авч үзье.

“...Хорих байгууллагын аюулгүй байдал, түүний удирдлага, зохион байгуулалтын асуудлын талаар...” хуулийн зохицуулалт нь урьд өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан ял

эдлүүлэх ажиллагааны чиглэлийн хуулиудад огт зохицуулаагүй бөгөөд 2017 онд шинэчлэн баталсан эрүүгийн хуульд “...хорих ангийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажиллах, зохион байгуулалтын талаар...” анх удаа тусгасан нь онцлог байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 241 дүгээр зүйлийн 241.1-т хорих ангийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь нэгдүгээрт, “...аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалт...”, хоёрдугаарт, “...техникийн хяналт, хамгаалалт...”, гуравдугаарт, “...биечилсэн хяналт, хамгаалалт...”, дөрөвдүгээрт, “...аюулгүй байдлын түвшин, эрсдэлийг үнэлэх...”, тавдугаарт, “...гүйцэтгэх ажил...” гэсэн хэсэгтэй байхаар хуульчилсан.

Аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтын асуудлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 242 дугаар зүйлийн 2.1-т “...Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үүрэг бүхий тусгай ажиллагааны нэгжтэй байна...” гэж заасан байна.

Эндээс үзэхэд “...Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил хорих байгууллагад үйлдэгдэх болон хорих байгууллагад хориотой эд зүйл нэвтрүүлэх, хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох...” асуудал нь “...Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тусгай ажиллагааны нэгжийн чиг үүрэгт хамаарна...” гэж ойлгож болохоор байна.

Хэдийгээр хуульд “...аюулгүй байдлыг хангах тусгай ажиллагааны нэгжтэй байна...” гэж заасан ч уг газар 2005-2019 оны хооронд Аюулгүй байдал, тусгай ажиллагааны газар, Тусгай ажиллагааны газар нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаад Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн б/25 дугаар тушаалаар татан буугдаж, аюулгүй байдлын чиглэлийн чиг үүрэг нь Тогтоол гүйцэтгэх газар буюу одоогийн Хорих ял эдлүүлэх албаны чиг үүрэгт багтсан явдал нь хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэл, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын том ухралт болсон гэж судлаачийн зүгээс үздэг.

Эндээс үзэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь “...байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах...” чиг үүрэг бүхий Аюулгүй байдал, тусгай ажиллагааны нэгжийг татан буулгасан явдал нь хорих байгууллагын хэмжээнд аюулгүй байдлын бодлого, чиглэлээр хангах “...удирдлага, зохион байгуулалтын үндсэн бүтэц, нэгжгүй...” болсон гэж үзэж болохоор байна.

Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, хорих ял эдлүүлэх алба нь хууль сахиулах аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий бүхий байгууллагуудтай “...хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны аюулгүй байдалд нөлөөлөх аюул, эрсдэлийн мэдээлэл солилцох...”, “...хорих ангид онцгой нөхцөл үүссэн үеийн үеийн харилцан ажиллагаа...”, “...тусгай техник хэрэгсэл, мэргэжлийн дэмжлэг авах...”, “...оргосон хоригдол, хоригдсон

этгээдийг эрэн сурвалжлах, алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад тусалцаа авах...”, “...хоригдол, хоригдсон этгээдийг нүүлгэн шилжүүлэх, хуяглан хүргэх ажиллагаанд дэмжлэг авах...” гэсэн үндсэн чиглэлээр хамтран ажиллахаар зохицуулсан байна.

Эндээс үзэхэд хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар, нэгжүүд аюулгүй байдлыг хангах тусгай ажиллагааны нэгжтэй “...Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил хорих байгууллагад үйлдэгдэх болон хорих байгууллагад хориотой эд зүйл нэвтрүүлэх, хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох...” чиглэлээр хамтран ажиллах талаар зохицуулалт алга байна.

Түүнчлэн тус хуулийн 243 дугаар зүйлийн 243.1-т “...Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах аюулгүйн тойрог тогтоох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батална...” гэж заасан нь хорих ял эдлүүлэх ажиллагаанд үйл ажиллагаанд мөрдөгдөж эхэлсэн билээ.

Аюулгүй байдлыг хангах удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр “...хорих ангийн аюулгүй байдлыг хангахад албаны нохой ашиглаж болно..”, “...Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дэргэд албаны нохойн сургалтын төвтэй байж болно...” гэж заасан нь “...байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох...” чиглэлээр шинэлэг зохицуулалт

болсон гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Эндээс үзэхэд “...Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил хорих байгууллагад үйлдэгдэх болон хорих байгууллагад хориотой эд зүйл нэвтрүүлэх, хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох...” зорилгоор хорих байгууллагад албаны нохой ашиглаж боломжтой байна.

Түүнчлэн “...хорих ангийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр болзошгүй гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох...” чиглэлээр “...эрх бүхий албан тушаалтан хууль, тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу гүйцэтгэх ажил явуулахаар...” тус тус зохицуулсан байна.¹

Үүнээс үзэхэд “...Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил хорих байгууллагад үйлдэгдэх болон хорих байгууллагад хориотой эд зүйл нэвтрүүлэх, хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох...” асуудал нь хорих ангийн аюулгүй байдлыг хангах асуудал хамаарах тул “...энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд гүйцэтгэх ажлын чиглэлийн ажил шууд хамаарна...” гэж ойлгож болохоор байна.

Хорих анги нь байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах асуудалд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиас гадна түүнд нийцүүлэн гаргасан “Хорих ангийн дотоод журам”, “Хорих ангийн харуул хамгаалалтын журам”-ыг удирдлага болгон ажилладаг бөгөөд тус журамд “...хорих ангид гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан

сэргийлэх...” чиглэлээр нэлээдгүй онцлог заалтуудыг тусгасан байна.

“Хорих ангийн дотоод журам”-ын 7 дугаар зүйлд заасан “...хоригдолд зөвшөөрөгдөх эд зүйлээс бусад зүйлийг хориглох ба зөвшөөрөөгүй эд зүйлийг биедээ болон байр эд зүйлдээ хадгалсан...” тохиолдолд зөрчилд тооцож, сахилгын арга хэмжээ авахаар зохицуулсан байна.

Мөн журмын 9 дүгээр зүйлд “...хорих анги дахь сургалтын талаар тусгасан бөгөөд хоригдлын дунд сургалтыг тогтмол зохион байгуулснаар гэм үйлдсэн хэргийн хор аюулыг ухамсарлах, дахин гэмт хэрэг үйлдэх болон хорих зан үйл, өөрийн ангид зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх...” нэг чухал ажил болсон байна.

Түүнчлэн тус журамд “...хоригдлыг хөдөлмөрлүүлэх, тэдний хөдөлгөөн байршил, чиглэл, хорих ангийн цагийн хуваарь зэргийг тусгайлан заасан...” бөгөөд “...журмыг мөрдөөгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар...” мөн тусгасан нь чухал ач холбогдолтой байна.²

Үүнээс гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 268 дугаар зүйлийн заасан “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны чиг үүрэг”-т “...согтуурах, мансууруулах донтох эмгэгтэй хүнийг албадан эмчлэх...” мөн хуулийн 267 дугаар зүйлд заасан “Хорих ангийн чиг үүрэг”-т “...Бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчтэй, согтуурах, мансуурах донтох эмгэгтэй хоригдлыг албадан эмчлэх...” үүрэгтэй гэж тус тус заасан

¹ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” /шинэчилсэн найруулга/ 2017он

² “Хорих ангийн дотоод журам”-аас

нь Хорих байгууллага нь “...энэ төрлийн бодист донтсон хоригдол, иргэдийг эмчлэх чиг үүргийг хэрэгжүүлж, удирдлага, зохион байгуулалтын асуудлыг хариуцан ажиллаж байгаа...” гэж ойлгож болохоор байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Монгол улсын Засгийн газрын 2000 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 148 дугаар тогтоолоор Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяанаас “Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар”-ыг өөрийн харьяанд авч энэ үеэс эхлэн согтуурах, мансуурах донтой этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх үйл ажиллагааг явуулж ирсэн.

Мөн энэ цаг үеэс эхлэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн болон түүнд донтох эмгэгтэй болсон этгээдүүдтэй харьцаж, гэмт зан үйлээс нь татгалзуулах, гэмт хэргийг дахин үйлдэхгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион явуулах шаардлага тулгарч эхэлсэн ба хорих ангид 2003 оноос энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгэгдсэн хоригдол ял эдэлж байсан түүхэн баримт байна.

Согтууруулах, мансууруулах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь үйл ажиллагаандаа 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан “Согтууруулах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх тухай хууль”-ийг баримтлан ажиллаж байна.¹

Согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх тухай хуулийн зорилт нь “...согтуурах, мансуурах донтой хүнийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хяналтан доор захиргааны журмаар албадан эмчлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах...” бөгөөд Согтуурсан, мансуурсны улмаас өөртөө болон бусдад аюул учруулах эрсдэлтэй байдалд орсон хүн согтуурах, мансуурах донтой болох нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч сайн дураараа эмчлүүлэхээс татгалзсан тохиолдолд Шүүхийн шийдвэрээр албадан эмчилгээнд хамруулж, донтох эмгэгийн оношийг тогтооход эрүүл мэндийн салбарт мөрдөж байгаа оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамжийг баримтлах ба согтуурч, мансуурсны улмаас өөртөө болон бусдад аюул учруулах эрсдэлтэй байдалд орсон хүнийг албадан эмчлүүлэх тухай хүсэлтийг өрхийн болон сумын эмч, эсхүл сэтгэц, наркологийн эмч, сум, хорооны нийгмийн ажилтан, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн эсхүл тухайн хүнийг албадан эмчлүүлэх тухай саналыг цагдаагийн байгууллагын алба хаагч бичгээр гаргаж болно гэж заажээ.

Мөн албадан эмчлэх эмнэлэг эмчлүүлэгчийн аюулгүй байдал, эмнэлгийн харуул хамгаалалтыг хариуцах ба эмчлүүлэгч албадан эмчлэх эмнэлгээс оргосон

¹ Ncs.cd.gov.mn хуудасны СМДӨАЭАХХГ-мэдээллээс

тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага эрэн сурвалжилж шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагаас туслалцаа авахаар тус тус заасан байна.¹

Эндээс үзэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа нь нэгдүгээрт, “...Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн хоригдлын гэмт санаа бодлыг арилгаж, засан төлөвшүүлэх болон энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын зүгээс үйлдэж болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх...”, хоёрдугаарт, “...Шүүхийн шийдвэрээр согтуурч, мансуурах донтой нь тогтоогдсон иргэнийг захиргааны журмаар албадан эмчлэх, түүнчлэн тэдгээрийн зүгээс гарч болзошгүй эрсдэл, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх...” чиг үүргийг мөн давхар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эндээс үзэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх нь ажиллагаа дан ганц “...энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлсэн хоригдлын хорих ялыг биечлэн эдлүүлж, согтуурах, мансуурах донг албадан эмчлэх...” ээс гадна “...захиргааны журмаар албадан эмчлүүлэх шийдвэр гарсан иргэдийг мөн хорт зуришаас татгалзуулах, албадан эмчлэх тэдгээрийн зүгээс гарч болзошгүй орголт, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх цогц ажиллагаа...” гэж судлаачийн зүгээс тодорхойлж байна.

Дүгнэлт

Дээрх бүгдээс үзэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлж, хорих ангид болон албадан эмчлэх газарт “...болзошгүй бүх төрлийн гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, түүнийг таслан зогсоох, илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж байгаа...” ч “...тусгайлсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хоригдолтой ажиллах, тэдэнд сургалт зохион байгуулах, хорих ангид энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхийг завдахаас урьдчилан сэргийлэх...” ажлыг зохион байгуулахад дагаж мөрдөх тусдаа хууль, журам байхгүй байна.

Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар бүтцийг зааж өгснөөс гадна байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийн нэг болох “...болзошгүй бүх төрлийн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, аюулгүй байдлыг удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх...” чиг үүрэгтэй нэгж болох “...Аюулгүй байдал, тусгай ажиллагааны газар болон нохойн албыг татан буулгасан нь...”, “...байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах болон мансууруулах эм,сэтгэцэд нөлөөт бодисын эсрэг тэмцлээс том ухралт хийсэн явдал...” гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Үүнээс гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба,

¹ "Согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх тухай хууль" 2018 он

салбар, нэгжүүд **аюулгүй байдлыг хангах тусгай ажиллагааны нэгжтэй** “...Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил хорих байгууллагад үйлдэгдэх болон хорих байгууллагад хориотой эд зүйл нэвтрүүлэх, хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох...” чиглэлээр хамтран ажиллах талаар зохицуулалт хуулийн зохицуулалт огт алга байна.

Санал

1. Хорих ял эдлүүлэх ажиллагаанд “...тусгайлан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хоригдолтой ажиллах, тэдэнд сургалт зохион байгуулах, хорих ангид энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхийг завдахаас урьдчилан сэргийлэх...” тухай хуулийг төслийг боловсруулан батлуулж үйл ажиллагаанд мөрдүүлэх;

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 242 дугаар зүйлийн 2.1-т “...Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үүрэг бүхий **тусгай ажиллагааны нэгжтэй** байна...” гэж заасны хэрэгжилтийг хангуулах, байгууллага алба хаагчийн аюулгүй байдлыг хангах болон нохойн албыг дахин шинэчлэн байгуулах;

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 242 дугаар зүйлийн “Аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалт” гэсэн хэсэгт “... хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар, нэгжүүд

аюулгүй байдлыг хангах тусгай ажиллагааны нэгжтэй “...Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил хорих байгууллагад үйлдэгдэх болон хорих байгууллагад хориотой эд зүйл нэвтрүүлэх, хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр хамтран ажиллана...” гэсэн зохицуулалтыг шинээр нэмэх гэсэн саналыг дэвшүүлж байна.

Эх сурвалжийн жагсаалт

- Б.Алтангэрэл. Гэмт хэрэгтний нийтлэг хэв шинж, сэтгэхүйн онцлог/мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг үйлдсэн хоригдлын жишээн дээр/. УБ., 2022.

- Б.Алтангэрэл. Албадан эмчлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт. УБ., 2023.

- Г.Хосбаяр. Хорих байгууллагад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис нэвтрэхээс урьдчилан сэргийлэх ажиллагаа, анхаарах асуудал. Хууль сахиулахын удирдлага онол, арга зүйн сэтгүүл. Дотоод Хэргийн Их Сургууль. 2021 он

- Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн тайлангаас

- Хандсан огноо. 2024.03.10: "Уголовный кодекс Российской Федерации" (УК РФ) от 13.06.1996 N 63-ФЗ (последняя редакция) \ КонсультантПлюс (consultant.ru)

- Хандсан огноо. 2024.03.10: Уголовный кодекс Китайской Народной Республики (china-embassy.gov.cn)